



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгоны 2 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2025/140/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: "Пийк Ом Аудит" ХХК

Утас: 99052418 Цахим хаяг: cheegii9989@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ	Error! Bookmark not defined.
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
3.1. Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2. Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	11
3.5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.5.1 Төсвийн төлөвлөлт	12
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	13
3.5.3 Нэмэлт төсөв:	14
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2. Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд :	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ Error! Bookmark not defined.	

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОУБ	Олон улсын байгууллага
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ЕРӨӨ СУМЫН БУГАНТ ТОСГОНЫ 2
ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
П.БАЯРЦЭНГЭЛ

2025.02.25 № СЭА-2025/140/НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгоны 2 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд тус цэцэрлэг нь сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 6,089.0 мянган төгрөгийн техник тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авсан бөгөөд Боловсролын Ерөнхий газрын даргын 2024 оны 11 дугаар сарын 14-ны өдрийн А/355 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 2 дугаар түвшинд үнэлэгдэж урамшуулалд 26,373.8 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас тус газрын тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 7 удаа

өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 20 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 95.2 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	192,585,757.18	180,797,458.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	150,154,067.18	131,999,268.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	150,154,067.18	131,999,268.00
3121	Төгрөг	150,154,067.18	131,999,268.00
31211	Төрийн сангийн харилцах	150,154,067.18	131,999,268.00
33	АВЛАГА		
34	УРЬДЧИЛГАА		
35	БАРАА МАТЕРИАЛ	42,431,690.00	48,798,190.00
354	Хангамжийн материал	42,431,690.00	48,798,190.00
3542	Аж ахуйн материал	31,721,990.00	34,211,340.00
3546	Хүнсний материал		398,650.00
3547	Бусад хангамжийн материал	10,709,700.00	14,188,200.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	974,016,255.18	948,838,400.16
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	974,016,255.18	948,838,400.16
392	Биет хөрөнгө	967,415,255.06	942,262,400.00
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,343,042,670.00	1,343,042,670.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-439,999,986.17	-464,223,402.65
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	47,010,770.00	52,969,770.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-23,105,559.43	-30,904,887.74
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	53,340,684.00	55,979,684.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-21,386,787.19	-29,642,047.78
39209	Зам, гүүрийн байгууламж		9,115,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	18,029,672.81	18,029,672.81
39215	Хуримтлагдсан элэгдэл	-9,516,208.96	-12,104,058.64
393	Биет бус хөрөнгө	6,601,000.12	6,576,000.16
39301	Программ хангамж	250,000.00	250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-74,999.88	-99,999.84
39303	Бусад биет бус хөрөнгө	6,426,000.00	6,426,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,166,602,012.36	1,129,635,858.16
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР		
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
413	Өглөг		
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,166,602,012.36	1,129,635,858.16
51	Засгийн газрын хувь оролцоо	1,166,602,012.36	1,129,635,858.16
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	345,227,609.00	345,227,609.00
51101	Өмч: - төрийн		
512	Хуримтлагдсан үр дүн	634,650,242.17	597,684,087.97
5121	Өмнөх үеийн үр дүн	634,650,242.17	634,650,242.17
5122	Тайлант үеийн үр дүн		-36,966,154.20
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	186,724,161.19	186,724,161.19
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,166,602,012.36	1,129,635,858.16

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,064,459,736.45	1,252,384,900.42
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	58,582,650.00	7,984,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	58,582,650.00	7,984,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	56,550,650.00	6,089,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	2,032,000.00	1,895,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,005,877,086.45	1,244,400,900.42
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	858,526,800.00	1,090,930,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	858,526,800.00	1,090,930,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,752,300.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21,752,300.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	125,597,986.45	153,470,200.42
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	125,597,986.45	153,470,200.42
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	896,478,215.00	1,289,351,054.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	896,478,215.00	1,289,351,054.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	882,339,215.00	1,272,208,054.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	529,562,574.99	845,478,261.08
210101	Үндсэн цалин	420,558,200.24	557,370,053.54
210102	Нэмэгдэл	84,529,439.75	238,330,581.41
210104	Урамшуулал	24,474,935.00	49,777,626.13
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,890,439.66	108,887,138.10
210201	Тэтгэврийн даатгал	45,605,485.11	73,123,425.41
210202	Тэтгэмжийн даатгал	8,669,116.35	8,899,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,357,549.60	4,614,612.69
210204	Ажилгүйдлийн даатгал	1,929,298.17	4,449,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,328,990.43	17,799,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	122,127,986.45	150,000,200.42
210301	Гэрэл, цахилгаан	10,699,425.45	11,152,760.42
210302	Түлш, халаалт	101,428,961.00	99,742,640.00
210303	Цэвэр, бохир ус	9,999,600.00	39,104,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,535,000.00	113,910.00
210402	Тээвэр, шатахуун		113,910.00
210408	Бараа материал ақталсны зардал	1,535,000.00	
2105	Нормативт зардал	91,365,000.00	96,431,850.00
210502	Хоол, хүнс	91,365,000.00	96,431,850.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,790,000.00	3,470,000.00
210604	Урсгал засвар	2,790,000.00	3,470,000.00
2107	Томилолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,450,200.00	2,720,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,450,200.00	2,720,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	62,618,013.90	65,106,195.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,276,960.00	13,641,353.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,265,250.00	8,573,987.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	43,075,803.90	42,890,855.02

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,139,000.00	17,143,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,139,000.00	17,143,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,139,000.00	17,143,000.00
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		
	Дотоод эх үүсвэрээр		
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	167,981,521.45	-36,966,154.20
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	167,981,521.45	-36,966,154.20

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,005,877,086.45	1,244,400,900.42
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		
120	Нийтлэг татварын бус орлого		
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,005,877,086.45	1,244,400,900.42
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	858,526,800.00	1,090,930,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	858,526,800.00	1,090,930,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,752,300.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21,752,300.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	125,597,986.45	153,470,200.42
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	125,597,986.45	153,470,200.42
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	865,318,683.16	1,250,931,699.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	865,318,683.16	1,250,931,699.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	851,179,683.16	1,233,788,699.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	528,968,557.05	845,478,261.08
210101	Үндсэн цалин	402,710,761.73	557,370,053.54
210102	Нэмэгдэл	99,418,470.38	238,330,581.41
210104	Урамшуулал	26,839,324.94	49,777,626.13
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,890,439.66	108,887,138.10
210201	Тэтгэврийн даатгал	48,888,800.89	73,123,425.41
210202	Тэтгэмжийн даатгал	5,712,050.90	8,899,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,464,220.77	4,614,612.69
210204	Ажилгүйдлийн даатгал	1,075,059.58	4,449,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,750,307.52	17,799,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	122,127,986.45	150,000,200.42
210301	Гэрэл, цахилгаан	10,699,425.45	11,152,760.42
210302	Түлш, халаалт	101,428,961.00	99,742,640.00
210303	Цэвэр, бохир ус	9,999,600.00	39,104,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал		
2105	Нормативт зардал	91,365,000.00	96,824,500.00
210502	Хоол, хүнс	91,365,000.00	96,824,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,470,000.00	3,470,000.00
210604	Урсгал засвар	3,470,000.00	3,470,000.00

2107	Томилолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,450,200.00	2,720,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,450,200.00	2,720,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,907,500.00	26,408,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,557,000.00	18,524,270.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,350,500.00	7,883,830.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,139,000.00	17,143,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,139,000.00	17,143,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,139,000.00	17,143,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	140,558,403.29	-6,530,799.18
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		11,624,000.00
	Дотоод эх үүсвэрээр		11,624,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		11,624,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		-11,624,000.00
145	Бусад эх үүсвэр		
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал		
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	140,558,403.29	-18,154,799.18
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		150,154,067.18
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		131,999,268.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	345,227,609.00	186,724,161.19	634,650,242.17	1,166,602,012.36
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
17	Тайлант үеийн үр дүн			-36,966,154.20	-36,966,154.20
19	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	345,227,609.00	186,724,161.19	597,684,087.97	1,129,635,858.16

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,394,554,900.42	1,262,555,699.60	131,999,200.82	90.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,394,554,900.42	1,250,931,699.60	143,623,200.82	89.7

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,377,411,900.42	1,233,788,699.60	143,623,200.82	89.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	965,251,700.00	845,478,261.08	119,773,438.92	87.6
210101	Үндсэн цалин	649,112,600.00	557,370,053.54	91,742,546.46	85.9
210102	Нэмэгдэл	279,397,700.00	238,330,581.41	41,067,118.59	85.3
210104	Урамшуулал	36,741,400.00	49,777,626.13	-13,036,226.13	135.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	114,272,500.00	108,887,138.10	5,385,361.90	95.3
210201	Тэтгэврийн даатгал	77,706,700.00	73,123,425.41	4,583,274.59	94.1
210202	Тэтгэмжийн даатгал	9,140,200.00	8,899,700.00	240,500.00	97.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,570,900.00	4,614,612.69	-43,712.69	101.0
210204	Ажилгүйдлийн даатгал	4,570,900.00	4,449,900.00	121,000.00	97.4
210205	Эрүүл мэндийн даатгал	18,283,800.00	17,799,500.00	484,300.00	97.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	150,000,200.42	150,000,200.42	0.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	11,152,760.42	11,152,760.42	0.00	100.0
210302	Түлш, халаалт	99,742,640.00	99,742,640.00	0.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	39,104,800.00	39,104,800.00	0.00	100.0
2105	Нормативт зардал	99,119,600.00	96,824,500.00	2,295,100.00	97.7
210502	Хоол, хүнс	99,119,600.00	96,824,500.00	2,295,100.00	97.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,470,000.00	3,470,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	3,470,000.00	3,470,000.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал			0.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,899,900.00	2,720,500.00	179,400.00	93.8
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,899,900.00	2,720,500.00	179,400.00	93.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,398,000.00	26,408,100.00	15,989,900.00	62.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,826,500.00	18,524,270.00	15,302,230.00	54.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,571,500.00	7,883,830.00	687,670.00	92.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,143,000.00	17,143,000.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,143,000.00	17,143,000.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,143,000.00	17,143,000.00	0.00	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		11,624,000.00	-11,624,000.00	
	Дотоод эх үүсвэрээр		11,624,000.00	-11,624,000.00	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,394,554,900.42	1,090,930,700.00	303,624,200.42	78.2
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,090,930,700.00	1,090,930,700.00	0.00	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,090,930,700.00	1,090,930,700.00	0.00	100.0
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	150,154,000.00		150,154,000.00	0.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого			0.00	
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	153,470,200.42	153,470,200.42	0.00	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	153,470,200.42	153,470,200.42	0.00	100.0
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		150,154,067.18		#DIV/0!
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		131,999,268.00		#DIV/0!

5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	39	39		100.0
6	Удирдах ажилтан	2	2		100.0
7	Гүйцэтгэх ажилтан	40	40		100.0
8	Үйлчлэх ажилтан	33	33		100.0
9	Гэрээт ажилтан	4	4		100.0

0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1. БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Ерөө сумын Бугант тосгоны 2 дугаар цэцэрлэг нь “Хүүхэд бүрийн өөрийн онцлог мөн чанарт нийцүүлэн үйлдлүүдэд хамруулан оюуны сэтгэх чадвар, бүтээлч үйлээрээ хөгжих суралцахад дэмжлэг үзүүлэх” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлсэн байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Цэцэрлэгийн насны бүх хүүхдийг боловсролын үйлчилгээнд тэгш хамруулж, СӨБ-ын хамран сургалтыг нэмэгдүүлэх,
- Багш ажлын байрандаа мэргэжлээ тасралтгүй дээшлүүлэх, заах арга зүй, ур чадвараа хөгжүүлэн, мэргэжил арга зүйгээ дээшлүүлэх,
- Хүүхдийн сурлага, хүмүүжил хөгжил, төлөвшил хамгааллын асуудлаар эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах гэрээ байгуулж, тэдний үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр санаачилгатай ажиллаж, хүүхдийн хөгжил төлөвшилд тодорхой ахиц гаргах,

3.2. БАЙГУУЛЛАГЫН ГАДААД, ДОТООД ОРЧИН

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;
- Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам” ;
- Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”;

- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;
- Засгийн газрын 2024 оны 05 сарын 29 өдрийн 237 дугаар тогтоолоор цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоосон;
- Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28–ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус цэцэрлэг нь БШУС-ын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, шинжлэх ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГО, ТОЛИЛУУЛГАД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТҮҮД

Ерөө сумын Бугант тосгоны 2 дугаар цэцэрлэг нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 36,966.2 мянган төгрөгөөр буюу 3.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	150,154.1	131,999.3	(18,154.8)
Авлага	-	-	-
Бараа материал	42,431.7	48,798.2	6,366.5
Үндсэн хөрөнгө	974,016.3	948,838.4	(25,177.9)
Нийт хөрөнгө	1,166,602.0	1,129,635.9	(36,966.2)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,166,602.0	1,129,635.9	(36,966.2)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,166,602.0	1,129,635.9	(36,966.2)

Дээрх хүснэгтээс үзэхэд дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 131,999.3 мянган төгрөг болж 18,154.8 мянган төгрөгөөр буурсан нь хөрөнгийн зарцуулалттай холбоотой байна.
- Бараа материал дансны үлдэгдэл 48,798.2 мянган төгрөг болж 6,366.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 180,163.3 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 1,895.0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, үйл ажиллагаанд 175,691.8 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 1,485,812.8 мянган төгрөг болж 17,713.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 11,624.0 мянган төгрөгийн техник тоног төхөөрөмж худалдан авсан, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 6,089.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авсан нь нөлөөлжээ. Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 536,974.4 мянган төгрөг бөгөөд 948,838.4 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй байна.

3.5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд улсын төсвөөс 960,292.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 157,383.3 мянган төгрөг, нийт 1,117,675.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг тогтмол зардлыг 5,554.5 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 796.6 мянган төгрөгөөр нийт 6,351.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, цалин хөлс, НДШ-ийн зардлыг 93,533.20 мянган төгрөгөөр, хүүхдийн хоолны зардлыг 39,772.1 мянган төгрөгөөр, урсгал засварын зардлыг 2,530.0 мянган төгрөгөөр, мэдээлэл технологийн үйлчилгээний зардлыг 147.2 мянган төгрөгөөр, тэтгэмж урамшууллын зардлыг 73,080.0 мянган төгрөгөөр нийт 209,062.5 мянган төгрөгөөр бууруулж 914,963.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайланд онд төсөвт 7 удаа зохицуулалт хийгдэж улсын төсвөөс 1,241,084.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 153,470.2 мянган төгрөгийн нийт 1,394,554.9 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэхээр эцэслэн баталсан байна. Үүнд:

- НДШ-ийн зардлыг 427,170.0 мянган төгрөгөөр,
- Тогтмол зардлыг 20,431.5 мянган төгрөгөөр,
- Мэдээлэл технологийн үйлчилгээний зардлыг 1,581.2 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 17,530.0 мянган төгрөгөөр,
- Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 17,143.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн гэх мэт

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр нийт 1,394,554.9 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж урсгал үйл ажиллагаанд 1,262,555.7 мянган төгрөгийг зарцуулж, 131,999.2 мянган төгрөгийг үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,262,555.7 мянган төгрөг буюу 90.5 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 129,704.1 мянган төгрөгөөр, хүүхдийн хоолны зардлыг 2,295.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/мянган төгрөгөөр/</i>							
	Хөтөлбөр	Д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Хувь
1	71802 Сургуулийн өмнөх боловсрол	1	802330- хүүхэд хамгаалал	1,280.8	1,280.8	-	100.0
		2	81605- Эрүүл мэндийг дэмжих	1,978.0	1,978.0	-	100.0
		3	81807- Цэцэрлэгийн хүүхдийн хоол	99,119.6	96,824.5	(2,295.1)	97.7
		4	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	3,478.5	3,478.5	-	100.0
		5	81823- Боловсролын багшийн сургалт	1,978.0	-	(1,978.0)	0.0
		6	81833-Явуулын багшийн үйлчилгээ	9,801.0	9,801.0	-	100.0
		7	81834- Боловсролын стандарт сургалт	1,070,014.5	942,288.4	(127,726.1)	88.0
		8	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	56,904.3	56,904.3	-	100.0
		9	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	150,000.2	150,000.2	-	100.0
		Нийт		1,394,554.9	1,262,555.7	-131,999.2	90.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хаасан байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулж, тайлагнаагүй, шууд худалдан авах босго үнээс давсан /2024 оны анх батлагдсан төсвөөр/ хүүхдийн хоолны зардал 99,119.6 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр тухай бүр гэрээ байгуулж, худалдан авалтыг хийж гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Ерөө сумын Бугант тосгоны 2 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн эцэг эхчүүдээс хүүхдийн сургалт, эрүүл ахуйн хэрэгцээнд үнэ төлбөргүй өгсөн хөрөнгийг орлогоор бүртгэж зарцуулалтад хяналт тавих зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Пийк Ом Аудит” ХХК-ийн аудитор Б.Наранчимэг, чанарын хяналтыг компанийн захирал Б.Жаргалсайхан, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Ерөө сумын Бугант тосгоны 2 дугаар цэцэрлэг нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 896,478.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 8,964.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Ерөө сумын Бугант тосгоны 2 дугаар цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд тус цэцэрлэг нь шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 20 төрлийн 171 мэдээллээс 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

- Санхүүгийн тайлан 1 удаа,
- Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой мэдээллийг 1 удаа,

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн шилэн дансны цахим хуудагд мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1 дэх

“Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана:”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Орон нутагт хүнсний бүтээгдэхүүний бөөний төвлөрсөн цэг байхгүй, зах зээл хомс шалтгаанаар үнийн харьцуулалт хийлгүйгээр “Дэвжих Бугант” ХХК, иргэн Ц.Оюунцэцэг нартай шууд гэрээ байгуулж худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой ... байх зарчмыг баримтална.”, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоолын хавсралтын 1: “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа-20.0 сая төгрөг” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

